



17

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 10 -10

Улаанбаатар хот

Мэдээлэл, технологийн инкубаторын  
“ахисан түвшин”-ийн үйл ажиллагааны журам батлах тухай,

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.10, 20.1.11,  
Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрмийн 6.6.7 дахь хэсгийн заалтыг  
үндэслэн ТУШААХ НЬ:

НЭГ. эдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторын “ахисан түвшин”-  
ийн үйл ажиллагааны журмыг хавсралт ёсоор БАТАЛСУГАЙ.

ХОЁР. Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторын ахисан  
түвшний үйл ажиллагааны журмыг 2020 оны 03 дугаар сарын 02-наас эхлэн  
дагаж мөрдөн ажиллахыг ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ГУРАВ. Мэдээлэл, технологийн инкубаторын “ахисан түвшин”-ийн үйл  
ажиллагааны журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төслийн  
удирдлага, сургалт, маркетингийн хэлтэс /П.Наранцэцэг/-т ҮҮРЭГ  
БОЛГОСУГАЙ.

ЗАХИРАЛ



Э.ЦОГТГЭРЭЛ



Ахисан түвшин  
1/а нийт

Мэдээлэл, технологийн үндэсний паркын  
2020 оны 03. сарын 02. өдрийн  
19-10 тоот захирлын тушаалын хавсралт 1

**МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ИНКУБАТОРЫН  
“АХИСАН ТҮВШИН”-ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1 Мэдээлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компанийг (цаашид хүсэлт гаргагч гэх) мэдээлэл, технологийн инкубаторт /ахисан түвшний/ (цаашид инкубатор гэх) сонгон шалгаруулж, элсүүлэх, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, инкубаторыг төгсгөх, инкубатораас хасахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2 “Ахисан түвшин”-ийн инкубаторын зорилго нь санхүүгийн болон үйл ажиллагааны хувьд тогтвортой, мэдээлэл, технологийн салбарт шинэ дэвшилтэй санааг бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах, шинэ хэрэгцээг эрж олох, шинэ технологид сууринсан бизнесийг хөгжүүлэхээр байгуулагдаад, гадаадын зах зээлд өрсөлдөх дэдэлээр туслалцаа шаардлагатай компанийд ажлын таатай орчин, менежментийн дэдэлээр туслалцаа үзүүлэх замаар тэднийг олон улсад өрсөлдөх чадвартай болгон өсгөн бойжуулахад оршино.
- 1.3 Инкубаторт элсэгч компанийд дэдэлэг үзүүлэх хугацаа 1-2 жил хүртэл байх бөгөөд хүсэлт гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний явцаас хамааран инкубатор байрлах хугацааг ажлын хэсэг тодорхойлно.
- 1.4 МТҮП-ын инкубаторт элсэн ороход “Инкубаторт компанийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журам”-ын мөрдлөгө болгох бөгөөд энэхүү журмын дагуу ажлын хэсгийг МТҮП-ын захирал томилж ажиллуулна.
- 1.5 Ажлын хэсгийн гишүүд нь сонгон шалгаруулалтанд ирсэн төслийн санаа, холбогдох мэдээллийн нууцлалыг чандлан сахих үүрэг хүлээнэ.
- 1.6 Инкубаторт Элсэгчийн бизнес төлөвлөгөө нь хамтын ажиллагааны гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна.
- 1.7 Элсэлтийн шалгуур үзүүлэлтүүд нь инкубаторт сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих үзүүлэлтийн үндэслэл болно.
- 1.8 Инкубаторт байрлах хугацаа дуусаад төгсөн гарсан компаниудад ахисан түвшний инкубаторын Шилдэг төгсөгч, Амжилттай төгсөгч гэрчилгээ олгоно.
- 1.9 Нэр томъёоны тайлбар:

**Ахисан түвшин гэж:** Технологид суурилсан бизнес эрхэлдэг санхүүгийн хувьд тогтвортсон, гадаад зах зээлд өрсөлдөх чадьар бүхий аж ахуйн нэгжийг хэлнэ

**Ажлын хэсэг гэж:** - Инкубаторт компанийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журам”, Хяналт- шинжилгээ хийх үнэлгээ өгөх журмаар батлагдсан орон тооны бус төлөөлөл

**Хуурамч мэдээлэл гэж:** татвар, шүүх болон бусад үйл ажиллагаатай холбоо бүхий бичиг баримт хуурамчаар үйлдэх

### **Хоёр. Инкубаторт элсэхээр хүсэлт гаргагч компаниудад**

#### **тавигдах шаардлага, нөхцөл**

- 2.1 Инкубаторт элсэхээр хүсэлт гаргагч компани нь дараах шаардлагуудыг хангасан байна.Үүнд:
  - 2.1.1 Мэдээлэл, технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байна.
  - 2.1.2 Инкубаторт дэмжлэг авах хугацаандаа мөрдөх, 1 жил тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавих бололцоо бүхий бизнес төлөвлөгөөтэй байх;
  - 2.1.3 Компанийн ажилчид мэргэжлээрээ мэргэшсэн түвшний англи хэлний мэдлэгтэй байх;
- 2.2 Хүсэлт гаргагч нь дараах болзол, нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:
  - 2.2.1 Инкубаторт байрлах хугацаанд ажлын байрны тогтвортой байдлыг хадгалан ажиллах;
  - 2.2.2. Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубаторт байрлаж буй гарааны 1-ээс доошгүй компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагаа өрнүүлэх;
  - 2.2.3 МТҮП-аас зохион байгуулж байгаа аливаа ажил, арга хэмжээнд (сургалт, семинар, шалгалт, салбарын спорт наадам) хамрагдах;
  - 2.2.4 Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалт, ТОПСИТ, ICDL шалгалтанд ажилтнуудаа тогтмол хамруулах;
  - 2.2.5 Нийгмийн хариуцлагаяа ухамсарлан олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах, оролцох;
  - 2.2.6 Хөрөнгийн болон үүрэг хариуцлагын баталгаа болох барьцаа төлбөр болох 2,500.000 (хоёр сая таван зуун мянга) төгрөг МТҮП-ын дансанд байршуулсан байх.
  - 2.2.7 Улирлын тайлан /тухайн байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээлэл/-г МТҮП-аас гаргасан маягтын дагуу

- тогтмол өгнө. . (Энэхүү мэдээллийг инкубаторын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг гаргахад ашиглана).
- 2.2.8 МТҮП-ын дотоод журам, инкубаторын үйл ажиллагааны журам болон бусад холбогдох дүрэм журмыг даган мөрдөж ажиллахаа зөвшөөрсөн албан бичиг ирүүлсэн байх.
- 2.2.9 Авлага, хөрөнгө оруулалтыг тооцоо нийлсэн актыг сар/улиралаар холбогдох ажилтантай хийсэн байх
- 2.2.10 Инкубаторт байх хугацаанд тухайн төсөл дээр хамтрагчаар дурдаж байх;
- 2.3 Компанийг ахисан түвшний инкубаторт элсүүлэх, дэмжлэг үзүүлэхдээ шударга, тэгш өрсөлдөөний зарчмыг баримтална.

### **Гурав. Элсэлтийн бүртгэл**

- 3.1 Инкубаторт элсэлт авах тухай зарыг сонгон шалгаруулалт өхлэхээс 14 хоногийн өмнө МТҮП-ын вэб сайтаар нийтэд зарлана.
- 3.2 Хүсэлт гаргагч компани нь дараах бичиг баримтуудыг бурдүүлэн заасан хугацаанд бүртгүүлнэ. Үүнд:
- 3.2.1. Инкубаторт элсэхийг хүссэн өргөдөл (МТҮП-аас гаргасан маягтын дагуу)
  - 3.2.2. Инкубаторт дэмжлэг авах хугацаандаа мөрдөж хэрэгжүүлэх 1 жил тутам үйл ажиллагаанд нь хяналт тавих бололцоо бүхий бизнес төлөвлөгөө (санхүүгийн ба үйл ажиллагааны) болон шинэ санааны төслийн бичиг баримт
  - 3.2.3 Хүсэлт гаргагч компани нь аж ахуйн нэгжийн дүрэм улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, хуулбарын хамт (нотариатаар баталгаажуулсан байх)
  - 3.2.4 Хүсэлт гаргагч нь компани нь сүүлийн нэг жилийн баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл (Улсад 30.000.000 төгрөг буюу түүнээс дээш татвар төлсөн байх)
  - 3.2.5 МТҮП-ын инкубаторын журам, хамтын ажиллагааны гэрээтэй танилцсан зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн албан бичиг
- 3.3 МТҮП нь инкубаторт элсэхийг хүсэгчдэд зориулсан зөвлөгөө өгнө.
- 3.4 Бүртгэлийн хураамжийн хэмжээ нь 250.000 төгрөг байна.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалт**

- 4.1 Ажлын хэсэг нь хүсэлт гаргагчийг дараах шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэнэ. Үүнд:
- 4.1.1 Шинэлэг бүтээлч санаа;
  - 4.1.2 Хэрэгжүүлэх боломжтой оновчтой шийдэл;
  - 4.1.3 Эдийн засгийн үр ашиг;
  - 4.1.4 Удирдлагын болон мэргэжлийн ур чадвар;
  - 4.1.5 Үйл ажиллагааны төлөвлөгөө;

- 4.2 Инкубаторт элсүүлэх сонгон шалгаруулалтын ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:
- 4.2.1 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь элсэлтийн баримт бичгүүдийг хүлээн авч, иж бүрдлийг шалгасны дараа битүүмжилнэ.
  - 4.2.2 Инкубаторт элсэгч компаниудад тавигдах шаардлагыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу, үнэн бодит бус хуурамч мэдээлэл ирүүлсэн хүсэлт гаргагчийг сонгон шалгаруулалтанд оруулахгүй.
  - 4.2.3 Хүсэлт гаргагч компанийд сонгон шалгаруулалтанд оруулах болсон талаар мэдэгдэж, тэдний битүүмжилсэн элсэлтийн материалыг шалгаруулалтын өдөр ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.
  - 4.2.4 Ажлын хэсгийн гишүүд хүсэлт гаргагчийг байлцуулан битүүмжилсэн элсэлтийн материалыг задалж, нэг бүрчлэн танилцана.
  - 4.2.5 Хүсэлт гаргагч нь сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралд шинэ санааны төсөл, бизнес төлөвлөгөөнийхөө талаар дэлгэрэнгүй (15-30 минут) танилцуулга хийнэ.
  - 4.2.6 Сонгон шалгаруулалт зохион байгуулсан өдөртөө багтаан дүнг зарлаж, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ
  - 4.2.7 МТҮП нь сонгон шалгаруулалтын дүнг зарласнаас хойш 10 хоногийн дотор инкубаторт элсэгч компанийтай хамтын ажиллагааны гэрээ байгуулна.

#### **Тав. Инкубаторын үйлчилгээ**

- 5.1 Инкубаторт байрлах хугацаанд компаниудад үзүүлэх багц үйлчилгээ нь энэхүү журмын салшгүй хэсэг байх бөгөөд шаардлагатай тохиолдолд МТҮП нэмэлт өөрчлөлт оруулна. (Хавсралт 2)
- 5.2 Инкубаторын компанийг ажлын байраар бүрэн хангана. Ингэхдээ ажлын байрны хөнгөлөлттэй нөхцлөөр байршуулна. (Хавсралт 2)
- 5.3 Ажлын байрны тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн компани өрөө танхим ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд ажлын байрны хүрэлцээг харгалзан шаардлагатай тохиолдолд талбайг нэмж ашиглуулж болно.
- 5.4 Олон улсын үзэсгэлэн яармагт зуучлах, компанийг хөтөлбөрүүдэд хамруулах, хурдасгуур хөтөлбөрүүдэд, зуучлах, дэмжлэг үзүүлэх
- 5.5 Компанийн ажилчдын ур чадварт тохирсон олон улсын сургалтуудад зуучлах, хамруулах, дэмжлэх үзүүлэх

#### **Зургаа. Инкубаторын компанийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх**

- 6.1 МТҮП-аас инкубаторын компаниудын үйл ажиллагаанд улирал, жил бүр хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгнө.

- 6.2 Улирлын үнэлгээг хариуцсан /газар, хэлтэс, төв, алба/-ны менежер гүйцэтгэнэ
- 6.3 Улирлын үнэлгээний явцад үйл ажиллагааны хувьд хангалтгүй үнэлгээ авч, цаашид үйлчилгээ үргэлжлэхгүй гэж үзвэл холбогдох /газар, хэлтэс, төв, алба/- аар хэлэлцүүлэн МТҮП-ын захирлуудын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлнэ
- 6.4. Нэг жилийн үнэлгээг “Мэдээллийн технологийн инкубаторын компаниудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журам”-ын дагуу хийнэ.
- 6.5 Нэг жил тутамд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ (цаашид үнэлгээ гэх)-г хийх ажлын хэсгийг “Инкубаторт компани, иргэнийг сонгон шалгаруулж элсүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсэг байгуулах журам”-ын дагуу МТҮП-ын захирлын шийдвэрээр томилно.
- 6.6. Нэг жилийн үнэлгээгээр 70-аас дээш хувийн дүн үзүүлсэн бол үргэлжлүүлэн байршуулах, төгсгөн гаргах шийдвэрийг ажлын хэсэг гаргаж, МТҮП-ын захирал баталгаажуулна.

#### **Долоо. Инкубаторыг төгсгөх**

- 7.1 Инкубаторын компани байрлах хугацаа нь дууссан бол төгсгөнө.
- 7.2 2 жилийн үнэлгээний дунджийг төгсөлтийн үнэлгээ гэж тооцно.
- 7.3 Инкубаторын компани инкубаторыг төгсөхдөө энэхүү журмын 6.6 дугаар заалтыг үндэслэх бөгөөд хөрөнгийн болон үүрэг хариуцлагын баталгаа болох барьцаа төлбөрийг буцаан олгоно.
- 7.4 Инкубаторт элсэгчдэд дэмжлэг үзүүлэх 2 жилийн дундаж үнэлгээ 90-100 хувийн дүнтэй төгссөн компанид “Инкубаторын шилдэг төгсөгч” гэрчилгээ олгоно.
- 7.5 Инкубаторыг 70-89 хувийн дүнтэй төгссөн компанид “Инкубаторыг амжилттай төгсөгч” гэрчилгээ олгоно.
- 7.6 Инкубаторын компани нь дараах нөхцлүүдэд хугацаанаас нь өмнө гаргаж төгсгөж болно.
  - Бүтээгдэхүүн үйлчилгээ нь зах зээлд нэвтрэхэд бэлэн болсон;
  - Хяналт-шинжилгээ үнэлгээ өгөх ажлын хэсгийн дүгнэлтээр төгсгөх шийдвэр гарсан тохиолдолд

#### **Найм. Инкубатораас хасах**

- 8.1 Дараах шалтгаануудын аль нэгийг үндэслэл болгон МТҮП-ын захирлын шийдвэрээр компанийг инкубатораас хасна. Үүнд:
  - 8.1.1 Улирал, 1 жилийн үнэлгээнд ороогүй бол;

- 23
- 8.1.2 Хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсгийн үнэлгээгээр 1 жилд 70-аас доош хувийн дүн үзүүлсэн бол;
  - 8.1.3 МТҮП болон үнэлгээний ажлын хэсэгт бодит бус хуурамч мэдээлэл бүрдүүлэн, өгсөн бол;
  - 8.1.4 Хамтын ажиллагааны гэрээ байгуулснаас хойш ажлын 10 хоногийн дотор инкубаторт байрлаагүй бол;
  - 8.1.5 Инкубаторын үйл ажиллагааны журам, хамтын ажиллагааны гэрээг ноцтойгоор зөрчсөн бол;
  - 8.1.6 МТҮП-ын дотоод журмын холбогдох заалтуудыг зөрчсөн бол.
- 8.2 Дараах нөхцөлд хөрөнгийн болон үүрэг хариуцлагын баталгаа болох барьцаа төлбөрийг буцаан олгохгүй.
- 8.2.1. 70-аас доош хувийн дүн үзүүлсэн бол дээрх барьцаа төлбөрийг буцаан олгохгүй.
  - 8.2.2. Энэхүү журмын 8.1-д заасан зөрчил гаргасан бол
- 8.3. Инкубаторын багц үйлчилгээг тухайн компанийд оруулсан хөрөнгө оруулалт гэж үзнэ. Хэрэв хугацаанаас өмнө хасагдсан тохиолдолд нийт оруулсан хөрөнгийг байрласан хугацааны өртгийг хасаж, үлдсэн үйлчилгээний хөрөнгө оруулалтыг тухайн үйлчилгээ авсан компанийд үзүүлэхгүй.

#### **Ес. Төгсөний дараах хамтын ажиллагаа**

##### **9.1. Хамтын ажиллагааны чиглэлээр**

- 9.1 Инкубаторыг төгсөгч ахисан түвшний компани нь шинээр элссэн компаниудад зөвлөгөө, сургалт, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зуучлах;
- 9.2 Гадаад болон дотоодын төсөл хөтөлбөр, тендерүүдэд хамтарч ажиллах,
- 9.3 Мэдээлэл, технологийн үндэсний паркаас зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд хамтарч ажиллах,
- 9.4. Нийгмийн хариуцлагын хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд паркын захирлын шийдвэрээр өрөө танхимыг үнэ төлбөргүй ашиглуулж болно.
- 9.5. Мэдээлэл, технологийн үндэсний паркын сургалтын танхим, хурлын заалыг хөнгөлөлттэй үнээр ашиглах
- 9.6 Инкубаторын үйлчилгээнд хамрагдсан компаниуд нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ паркад хөнгөлттэй нөхцөлөөр ашиглуулах;

Мэдээлэл, технологийн инкубаторын “АХИСАН ТУВШИН”-ийн  
журмын хавсралт 2  
ТӨГСЧИЛГЭЭН НӨХЦЭЛ  
ГОДАА ГҮРҮҮЛЭХ

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ИНКУБАТОРЫН “АХИСАН ТУВШИН”-ИЙН  
КОМПАНИУДАД ҮЗҮҮЛЭХ БАГЦ ҮЙЛЧИЛГЭЭ

			Төлбөр ₮		
Багц	Багц үйлчилгээний төрөл	Үйлчилгээний нэр	Нийт 24 Сар	Хөнгөлгөөний дүн /Инкубатор/ Жишээ 100м2	Үндсэн үнийн дүн /1м2 35.000 ₮/ Жишээ 100м2
Багц-1	Ажиллах орчин Ажлын Байр	Ажлын байрны түрээсийн төлбөрийг улирлаар нь шаталсан хөнгөлөлт	1-р жил - 65%  2-р жил - 55%	14.700.000  18.900.000	27.300.000  23.100.000
		Нийт	33.600.000	50.400.000	84.000.000
Багц-2	Олон улсын арга хэмжээ, бусад	Ажилтан солилцоо хөтөлбөрт зуучлах  Олон улсын сургалтанд зуучлах зуучлах  Олон улсын үзэсгэлэн яармагт зуучлах  Олон улсын үзэсгэлэн яармагт зохиогчийн эрх Технологи дамжуулалт Патент, барааны тэмдэгтийн эрх зүйн ойлголт  Бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн	0  0  0  0  0  0  0	0  0  Шаардлагатай тохиолдолд  500,000  800,000  1,000,000	0  42.000.000  84.000.000

Багц-3	Програм хангамж	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлах	МТҮП болон салбар байгууллагуудын вэб сайт болон олон нийтийн хэвлэп, мэдээллээр бүтээгдэхүүн үйлчилгэг сурталчлах	Дүн	0	630,000	2,000,000
		VPS-ийн багц Интернет холболт	VPS үнэзүй түрээслэх эрх Үзүүлэлт: CPU 4 core 1GHz, RAM 4GB, HDD 120GB/ 1MB интернэтийн ургсал	Сар бүр Дүн	0	2.130.000 1.500,000 1,500,000 0	3,800,000 2,400,000 3,600,000 6,000,000
		Нийт хөрөнгө оруулалтын дүн	93.800.000₮ (Нийт зардал)	60.200.000₮ (Инкубаторын компаниас гарах зардал)			
							(Паркаас үзүүлж буй хөрөнгө оруулалт)